

## УЙГАРЫН НИЙСЛЭЛ ХАРБАЛГАС ХОТЫН АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТОВЧ ТОЙМ



*Уйгурын эзэнт гүрний нийслэл Ордубалык буюу Хар балгасын туурь*

### **Орхоны шинжилгээний анги 1891 он**

1891 оны 7-р сарын 16-нд Оросын түрэг судлаач, эрдэмтэн Вильхельм Радловын удирдсан шинжилгээний анги Орхоны хөндийд хүрэлцэн ирж хүрэлцэн Хотонт сумын нутагт орших Харбалгас/нутгийн иргэдийн нэршил/ хэмээх эртний хотын үлдэгдэл /туурь/-ийг судалснаар Уйгар улсын нийслэл Харбалгас хотын туурийг судлах судалгааны ажил эхэлжээ.

Уг шинжилгээний анги хотын туурийг 12 хоногийн турш судлан үзэж байгууламжуудыг зохих хэмжээстэй нь баримтжуулж, хотын анхны дэвсгэр зургийг үйлдсэн бөгөөд “**Монголын хуучны дурсгалт зүйлсийн атлас**” хэмээх бүтээлдээ нийтлүүлсэн юм. Экспедицийн гишүүдэд хотын ор үлдэгдэл гүнзгий сэтгэгдэл төрүүлсний адил юуны өмнө тэнд байсан хагархай чулуун хөшөөний бичээсийг шинжлэх ухааны үүднээс онцгойлон сонирхсон. Орхоны түрэг, согд, хятад гурван хэл дээрх бичээст хөшөө нь хэдэн хэсэг хуваагдан хэдэн зууны турш газар хэвтэж байсныг Радловыг ирэхээс 2 жилийн өмнө 1889 онд Н.М.Ядринцев согд хятад бичээстэй 2 том хагархайг Санкт-Петербург хотноо аваачсан нь тэр үеийн өрнөдийн судлаачдад танил болсон байжээ. 808-832 оны хооронд босгосон хэмээн үзэж буй

уг гэрэлт хөшөөнд Уйгурын мандал бадрал, их ялалтын тухай өгүүлсэн бөгөөд согд багш нар Уйгурын дунд залран ирж номлон дэлгэрүүлж байсан манихейн шашны талаар дурдсан нь түүхийн судалгааны асар үнэтэй баримт юм. Хөшөөний хоёр хугархай дээрхи хятад бичээсийг анх эрдэмтэн Э.Кох уншиж 1891 онд орос, франц хэлээр нийтлүүлжээ. Үүний дараа Орхоны шинжилгээний ангийн гишүүн, хятадач эрдэмтэн В.П. Васильев тухайн үед Санкт-Петербург хотноо сууж байсан Хятадын элчин Шу-Кин-Чен гэдэг хүний нийлүүлж өгснөөр тухайн цаг үеийн судлаачдын мэдэлд орсон Харбалгасны гэрэлт хөшөөний хятад бичээсийг нэгтгэн уншиж 1895 онд герман хэлээр, 1897 онд оросоор хэвлүүлсэн билээ. Харин Харбалгасны нэгдүгээр түрэг бичээс хэмээн судлаачдын дунд алдаршсан руни бичээсийг Радлов анх түрүүн тайлан уншиж гэрэл зураг хэв дардасыг нь “ Монголын хуучны дурсгалт зүйлсийн атлас “ таа хэвэлсэн ба 1895 онд германаар орчуулан “Монгол дахь эртний түрэг бичээсүүд” номондоо үгийн галиг, тайлбар толийн хамт нийтлүүлсэн байдаг. Хар балгасны согд бичээсийн талаар 1930 онд 1930 онд Германы эрдэмтэн Олаф Хансен, 1990 онд Японы эрдэмтэн Юутака Ёшида нар нарийвчлан судалж тусгай өгүүлэл нийтлүүлсэн бол хөшөөний бичээсийг дахин судлах ажлыг 1996-1997 онд Монгол- Японы хамтарсан “Бичээс” төслийнхөн 2001 ба 2004 онд Казакстаны түрэг судлаач Базылханы Напильн удирдсан шинжилгээний анги тус тус хийж гүйцэтгэсэн ажээ.

### **Хангай экспедиц 1934**

Зөвлөлтийн эрдэмтэн Д.Д.Букинич 1934 онд Харбалгасын үлдэгдэл дээр 8 цооног малтсан байдаг. Букиничийн судалгааны тайлан ШУА- ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж байна

### **Монгол зөвлөлтийн түүх угсаатэн зүйн хамтарсан экспедици 1948/1949**

Зөвлөлтийн археологич, профессор С.В.Киселевын удирдсан Монгол зөвлөлтийн шинжилгээний анги 1948-1949 онд Монгол оронд явуулсан археологийн судалгааны нэгээхэн хэсгийг Хар балгасны үлдэгдэл дээр хийсэн. Энэ тухайгаа “Зөвлөлтийн археологи “ сэтгүүлийн 1957 оны 2 дугаарт нийтлүүлсэн “ Монголын эртний хотууд” өгүүлэлдээ Харбалгасд хийсэн ажлынхаа тухай дурьдсан байдаг. Энэхүү өгүүлэлдээ 1891 онд В.В.Радловын экспедицийн судалгаа ба Клеменцийн тодорхойлолтыг нягтлахад ажлаа чиглүүлсэн гэдгээ дурдаад юуны өмнө тэр үед хийгдсэн хотын дэвсгэр зургийг дахин нарийвчлан тодруулж, малтлагын ажлыг Хар балгасны зөвхөн их хэрмийн гол төв

хэсэгт явуулсан тухайгаа мэдээлсэн байна. Түүний малтлага хийсэн газраас олдсон зүйлүүд Тан улсын /618-907/ үед холбогдох барилгын чимэглэл, дээврийн ваар, 840 оны үед холбогдох зоос тэргүүтэн байжээ. Үүнээс үндэслэн Харбалгасны төв хэсэгт цайзат хэрэм бүхий хааны ордон, түүний гадуур орон сууцны хороолол, мөн түүнчлэн Уйгурын хаадад зориулан босгосон гэрэлт хөшөө үүдэнд нь тавиастай байгаа нь сүм дуганы барилгын чуулбар байсан гэж үзжээ. Түүнчлэн хотын дэвсгэр дэх нэгэн барилгын үлдэгдлийг малтаад энд төмөрлөг боловсруулах ажил хийж байсан гэж дүгнэжээ.

### **Монгол- Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан**

#### **экспедицийн хийсэн судалгаа 1976/1979**

Энэ шинжилгээний ангийн хээрийн судалгааны ажлын хүрээнд 1976 ба 1979 оны зун археологич Д. Цэвээндорж, Ю.С. Худяков нар Харбалгасны үлдэгдлийг шинжин үзэж, гол хэрэмт байгууламжийн тойм зураглал хийсний зэрэгцээ шавар вааран эдлэл голдуу түүвэр олдвор цуглуулсан байна. Энэ судалгааны ажлын үр дүнд 1982 онд монгол орос хоёр эрдэмтний хамтран бичсэн “Ордубалыкийн керамик” 1990 онд Ю.С.Худяковын “ Монгол дахь Уйгурын соёлын дурсгалууд “хэмээх бэсрэг өгүүлэл нийтлэгджээ. Мөн энэ үеийн чухал нээлтийн нэг бол эрдэмтдийн дунд Хар балгасны 2-р түрэг бичээс хэмээн нэршсэн хөшөөг олж судалсан явдал юм. 2007 оны зун Монгол- Германы “Орхон” экспедици зохион байгуулагдсан юм. 2009 оноос эхлэн Герда Хенкель сангаас санхүүжүүлж буй “Орхоны хөндий- Харбалгас “ хэмээх төсөл Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн Хүрээлэнтэй нягт хамтын ажиллагаа явуулан хэрэгжүүлж байна. Хуучны судалгаагаар хотыг 25 орчим ам дөрвөлжин км гэж байсан бол агаарын лазерскийн судалгааны үр дүнгээр Харбалгас нь дор хаяж 32 км хавтгай дөрвөлжин талбайг эзлэн оршино гэж үзсэн байна.

#### **2009 оны 8-9 дүгээр сард хийсэн анхны малталт**

2009 оны зун цаг агаарын байдал хийгээд логистикийн бэрхшээлээс шалтгаалж гурван долоо хоног гаруйхан богинохон хугацааны малтлага хийсэн. Хар балгас дахь малтлагууд нь юуны өмнө, ордон юмуу сүмийн хот хэмээн нэрлэгддэг газрын доторхи хоёр жижиг барилгын турь ба их хэрэмт байгууламжийн өмнө орших нэгэн томоохон байгууламжийн дээр тус тус төвлөрөн явагдлаа. Их суварганы зүүн талд орших барилгын дов дээр С.В.Киселевийн малтлагын хуучин нүхийг хөөж цэвэрлэж үзэв. Түүний малтлагын байдлыг сэргээн

төсөөлсний дараа , уг малтлагын талбайг бага зэрэг тэлж өргөтгөсөн бөгөөд суурин амьдралын үе давхрагын байдал ба барилга байгууламжийн хүрээ хязгаарын талаархи эхний ойголтыг авахын тулд хэсэгчилсэн байдлаар эх газрын ул хөрс хүртэл гүнзгийлэн малтав.

Малтан судалсан туслах барилгын баруун өмнөд хэсэгт, байшин хаягдаж орхигдсоноос хожим хойно аваачиж тавьсан нэгэн залуу хүний оршуулга илэрсэн юм. Булшийг оршуулгын зан үйл, зүг чиг, хойлгын эд зүйл ба булшны хэлбэрийн онцлог шинжээр нь эртний монголын үеийнх / XII-XIV зуун/ хэмээн он цагыг нь тогтоосон байна.Энэ нь монголын үеийн хөмөгт булш болох нь илэрхий байсан бөгөөд хүүрийн толгойг хойд зүг чиглүүлэн биеийг нь байшингийн баруун хана дагуу зэрэгцүүлэн тэнэгэр байдлаар тавьжээ.Булшны хөмгийг байшингийн хатуу шавар ханыг хөндийлөн ухаж хийжээ.

### **Монгол-Германы хамтарсан “Орхон” шинжилгээний ангийн хийсэн археологийн судалгаа**

Монгол-Германы Орхон экспедици 2007-2019: 1999 оноос эхлэн Монголд үйл ажиллагаагаа амжилттай явуулсан Монгол-Германы “Хархорум” экспедици (MDKE) цаашид Монгол-Германы “Орхон” экспедици (MONDOгEX) болон өөрчлөгдөн зохион байгуулагдаж судалгаа шинжилгээний ажлын цар хүрээгээ тэлсэн билээ.

Монгол-Германы хамтарсан “Орхон” экспедици Хар Балгасын их хэрмийн цитадель (шороон байгууламж) дээр гол судалгаагаа төвлөрүүлэн ажилласны зэрэгцээ 2018 оны 8 сарын 1-нээс 8 сарын 21-нд хотын их хэрэмт байгууламжаас урагш 3,9 км зайд, төв гудамжны төгсгөл хэсгийн зүүн талд байрлах нэгэн овгор шороон байгууламжийг өмнөх жил сонгон авч шинээр малтлага судалгааны ажил эхлүүлж байсныг үргэлжлүүлэв. Энэхүү байгууламж нь гадуураа шороон хэрэмтэй ба дотроо хэд хэдэн овгор шороон барилгын туурьтай. Энэхүү хэсгийг хотын дэвсгэр талбайд хийсэн малтлагын баримтжуулалтын дарааллын дагуу НВ 4 гэж нэрлэн туурийг 24x24 метр урт 2 м өргөнтэй 96 ам дөрвөлжин талбайд малталт судалгаа хийсэн бөгөөд энэхүү судалгаагаар эртний барилгын суурь довжооны үлдэгдэл илэрч олдсон байна. Мөн НВ 4 хэсгийн малтлагаар вааран сав суулганы хагархай, тамга тэмдэгтэй дээврийн ваар зэрэг олдворууд олдсон байна.



Хар Балгасын цайзат хэрмийн баруун урд буланд орших цитадельд (шороон байгууламж) дээр 5 жилийн турш малтлага судалгаа хийж 2018 онд явуулсан археологийн малтлага судалгаагаар боржин чулуун хавтанг зургаан тал гарган 12 үеэр өрж доторлосон худаг илрүүлэв. Уг худаг нь 13 метр орчим гүнтэй байсан ба дотроос нь шавар ваар, хятад бичигтэй, төмөр хэлтэй, хүрэл хонх, хэд хэдэн ваар, ургамлын дүрсээр хээлсэн чий будагтай модон шонгийн хугархай хоёр ширхэг олдсон нь нүүдэлчдийн гар урлал өндөр түвшинд хөгжиж байсан хийгээд гадаад харилцааг илэрхийлэх гэрч баримт юм.

ийн чулуугаар  
йдал

Худгийн ёроолоос гарсан  
хүрэл хонх

Монгол Улсын Засгийн Газрын 2002 оны 04 сарын 17-ны өдрийн 71 тоот тогтоолоор соёлын үл хөдлөх дурсгал болох Харбалгасын хамгаалалтын бүсийг 39.8 кв км байхаар тогтоожээ.


Харбалгасын баруун урд хажууд түүнээс .....км-ийн зайд орших Дөрвөлжин, Хулхын ам дахь хиргисүүрүүдийн археологийн малтлагаар илрүүлсэн олдвор,



уйгарын язгууртнуудын булш хиргсүүрүүдийн тухай товч тайлбарыг зургийн хамт энд байршуулах

## ХАР БАЛГАС ХОТЫН ТУУРИЙН УЛСЫН ХАМГААЛАЛТЫН ХИЛ

МОНГОЛЫН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2002 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ  
71 ДУГААР ТОГТООЛООР УЛСЫН ТУСТАЙ ХАМГААЛАЛТАНД АВСАН.



### Таних тэмдэг

 Хамгаалалтын бүс

1	102°35'1.4"E	47°24'41.94"N
2	102°37'35"E	47°27'58"N
3	102°40'9.6"E	47°26'50.5"N
4	102°40'40.6"E	47°24'34.4"N
5	102°39'42.1"E	47°23'5"N

Масштаб 1:50000

1-5 Хамгаалалтын бүсийн  
цэгийн координат

## **Дөрвөлжингийн бунхант булшнуудын цогцолбор**

*Архангай аймгийн Хотонт сумын төвөөс зүүн урагш 20 орчим км, Хар балгас хотын тууриас баруун урагш 10 гаруй км, Хархориноос баруун хойш 10 гаруй км-ийн зайд орших Өвөр хавцалд 10, үүний урд талын зэргэлдээх Хулхийн аманд 2, Хундын хоолойд 8 тооны дөрвөлжин бунхант булшны цогцолбор байдаг. Булшнууд нь тэгш өнцөгт хэлбэртэй, гадна талдаа үерийн ус зайлуулах шуудуу бүхий шороон далантай, дотор талыг нь чулуу, тоосгоор барьсан бунхант байгууламж юм. Монгол-Хятадын хамтарсан шинжилгээний ангийн 2005-2014 онд хийсэн археологийн малтлага, судалгаагаар VIII-IX зууны Уйгурын эзэнт гүрний язгууртнуудын булш болохыг тогтоов. Малтлагаар 6 бунхант булш, амьтны нүүрний дүрс, бичээс бүхий дээврийн ваар, шавран болон алт, мөнгөн гоёлын чимэглэл, хүрэл зоос, булшны ханын 5 тооны ижил цэцгэн хээ зэрэг нэн ховор олдворуудыг илрүүлжээ.*

### **ХУНДЫН ХООЛОЙН ТАВДУГААР ДӨРВӨЛЖИН**

2008 онд Монгол-Хятадын судалгааны анги Архангай аймгийн Хотонт сумын Хундын хоолойд археологийн малтлага явуулжээ.


Судалгааны баг Хундын хоолойн долоон дөрвөлжингийн хамгийн том нь болох 5-р Дөрвөлжинд малтлага хийж, малтлагын үр дүнд тоосгон бунхан илэрч, бунхны дотор хананд зурсан **туурган** зураг илэрсэн нь нэн сонирхолтой юм.

Зургийн үндсэн сэдэв нь цэцэг, ургамлын дүрст хээ бөгөөд улаан хүрэн, цагаан, хар өнгийн будгаар бадам цэцгийг олон давтамжтайгаар дүрсэлжээ. Бадам цэцэг нь дорнын ард түмний дунд амар амгалангийн бэлгэдэл болдог. Тухайн зургийн өнгө будгийн зохицол, дүрслэлийг харвал ихээхэн ур чадвартай үйлдсэн болох нь ажиглагдана. Уг зураг нь тухайн үеийн дүрслэх урлаг, уран зургийн түвшинг харуулах биет дүрсгал болж байна.



*Зураг 1. Хундын хоолойн 5 дугаар дөрвөлжингийн бунхны ханан дахь бадам цэцэгэн хээ.*





*Зураг 2. Бунхны 3D байдлаар сэргээн төсөөлсөн загвар.*



*Зураг 3. Хундын 5 дугаар дөрвөлжингийн ойролцоох булшнаас илэрсэн хоёр төрлийн алтан ээмэг, алтан товч.*



Зураг 4. Хундын 5 дугаар дөрвөлжингийн ойролцоох булшнаас илэрсэн зоосны хагархай болон хүрэл эд хэрэглэл.



Зураг 5. Хулхийн амны нэгдүгээр дөрвөлжин болон наймдугаар монгол булшны малтлагаар илэрсэн маш нарийн хийцтэй алтаар урласан тана, оюу, номин чулуун шигтгээтэй богтаг малгайн цох .

## ДОМГИЙН АМЬТНЫ ДҮРСЛЭЛТЭЙ ВААР

2009 онд Монгол-Хятадын хамтарсан судалгааны ангийн судлаачид Архангай аймгийн Хотонт сумын Өвөрхавцалын амны зургаадугаар Дөрвөлжингийн малтлагаар домгийн амьтны дүрслэлтэй ваарыг илрүүлжээ. Ийм дүрслэлтэй шавар чимэглэлийн хагархай өмнө нь хэдэнтээ олдож байсан боловч хамгийн сайн хадгалагдсан, харьцангуй бүтэн нь уг олдвор юм.

Уг ваарыг саарал өнгөтэй, нарийн ширхэгтэй шавраар ур хийц сайтай үйлдсэн, шатаалт сайтай. Түрэг угсаатнууд тахилын онгон, шүтээний сүмийн барилгын чимэглэлд догшин ширүүн төрхтэй, үлгэр домгийн сүрлэг амьтад болон чулуун арслан зэргийг үйлдэн тавьдаг байжээ. Энэ нь барилгыг чимэглэхийн сацуу шүтээний газар муу муухай зүйлийг оруулахгүй, хөөн зайлуулах гэсэн утга агуулгатай ажээ. **Өвөрхавцалын амны зургаадугаар Дөрвөлжингөөс гарсан энэхүү олдвор нь урт төвгөр эвэр, түрэмгий догшин нүдтэй, хурц соёо бүхий сүрлэг амьтны дүрслэл бөгөөд Уйгурын нийслэл Харбалгас, ОХУ-ын Тувагийн Порбажын зэрэг VIII-IX зууны үеийн уйгурын хот суурингаас олддог байна.**

Уг олдвор нь Түрэгийн үеийн барилгын чимэглэл болоод Хятадын Тан улсын чимэглэлүүдээс өвөрмөц ялгаатай ажээ. Энэ чимэглэлийг сүм дуган, барилгын багана, дээврийн уулзвар хэсэгт байршуулдаг байсан бололтой.



*Зураг 6. Өвөрхавцалын амны 6 дугаар дөрвөлжингийн малтлагаас илэрсэн барилгын шавар чимэглэлүүд.*





*Зураг 7. Өвөрхавцалын амны 6 дугаар дөрвөлжингийн малтлагаас илэрсэн сүм дуган, барилгын багана, дээвэрт байрлуулдаг чимэглэл(хажуу талаас).*



*Зураг 8. Өвөрхавцалын амны 6 дугаар дөрвөлжингийн малтлагаас илэрсэн сүм дугана, барилгын багана, дээвэрт байрлуулдаг чимэглэл(эгц урд талаас).*

## Ном зүй

1. Соёлын өвийн үндэсний төв, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах, Улаанбаатар 2017 он
2. Д. Цэвээндорж, Н.Уртнасан. Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгаын хадгалалт хамгаалалт, Улаанбаатар 2008 он
3. ШУА, Археологийн хүрээлэн. Монголын археологи-2014. Улаанбаатар 2015он
4. Соёлын өвийн төв, Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал Х дэвтэр, Архангай аймаг Улаанбаатар 2013 он
5. Монголын археологи -2018 он Улаанбаатар 2019 он